

Тендерийн урилга

Огноо:	2023 оны 7 дугаар сарын 6-ны өдөр
Зээлийн дугаар ба нэр:	Зээл 3843/3844-MON: “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” – I үе шат
Гэрээний дугаар ба нэр:	БА03: Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын эрүүл мэндийн төв (2)-ийн барилгын ажил

1. Монгол Улс нь Азийн хөгжлийн банк (АХБ)-аас “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” I үе шат төслийг санхүүжүүлэх зорилгоор энэхүү санхүүжилтийг хүлээн авсан бөгөөд уг хөрөнгөөр дээр дурдсан гэрээний төлбөрийг санхүүжүүлэх зорилготой болно. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендер оролцогчдод нээлттэй байна.
2. Эрүүл мэндийн яам (“Захиалагч”) нь эрх бүхий тендер оролцогчийг **БА03: Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын эрүүл мэндийн төв (2)-ийн барилгын** (“Ажил гэх”) ажлыг хийж гүйцэтгэх, дуусгах тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.
3. Нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (дотоодод зарлан мэдээлэх)-ыг АХБ-ны **нэг үе шаттай: нэг дугуйт** горимын дагуу зохион байгуулах ба тендерийн баримт бичигт заасан эрх бүхий орны бүх тендер оролцогчдод нээлттэй байна.
4. Энэхүү тендер шалгаруулалтад зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шаардлагыг хангасан эрх бүхий тендер оролцогч оролцоно. Үүнд:
 - **Санхүүгийн үзүүлэлт:**
Тендер оролцогчийн одоогийн санхүүгийн чадавхийг харуулах үүднээс сүүлийн 3 жилийн (2020, 2021, 2022) аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, эсхүл тендер оролцогчийн харьяа орны хуулиар аудитаар баталгаажуулахыг үл шаардсан бол захиалагчийн зөвшөөрөх бусад хэлбэрийн санхүүгийн тайланг илгээнэ. Тендер оролцогчийн цэвэр хөрөнгийн доод хэмжээг нийт актив хөрөнгө ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцох ба энэ зөрүү нь ашигтай байна.
 - **Барилгын ажлын жилийн дундаж борлуулалт:**
Сүүлийн 3 жилд (2020, 2021, 2022) хэрэгжиж байгаа эсхүл хэрэгжиж дууссан гэрээт ажлын хүрээнд хийгдсэн нийт баталгаат төлбөрийн дүнгээр тооцож гаргасан барилгын ажлын жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ **2.85 тэрбум** төгрөг байна.
 - **Санхүүгийн нөөц хөрөнгийн шаардлага:**
Тендер оролцогч нь одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр **475.0 сая** төгрөгийн санхүүгийн чадварын шаардлагыг хангах хүрэлцээтэй санхүүгийн нөөц хөрөнгөтэй байх.
 - **Төрөл ба хэмжээгээр төстэй гэрээний туршлага:**
Сүүлийн (3 жилд 2020, 2021, 2022) амжилттай эсхүл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, мөн санал болгож буй ажилтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд оролцсон байх, ингэхдээ тендер оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнэлгээ нь **2.8 тэрбум** төгрөгөөс доошгүй байх.
 - **Үндсэн үйл ажиллагааны барилгын ажлын туршлага:**
 - (i) 800 кв-аас багагүй талбай цутгамал төмөрбетон араг бүтээцтэй барилга барьж байсан туршлагатай байх.
 - (ii) Хамгийн багадаа 250 кв авто замын сүлжээ барьж байсан туршлагатай байх.

- (iii) Эмнэлгийн нарийн мэргэжлийн оношилгоо эмчилгээний тусламж үйлчилгээний халдваргүй, ариун орчныг бүрдүүлэхүйц өрөө тасалгааны шинэчлэл засвар үйлчилгээ хийж байсан туршлагатай байх.
5. Дэлгэрэнгүй мэдээлэл авах болон тендерийн баримт бичигтэй танилцах сонирхолтой эрх бүхий тендер оролцогч нь дараах хаягаар хандана:.

Захиалагч : Эрүүл мэндийн яам
Харилцах ажилтан : Н.Бямбасүрэн, Төслийн ХАА-ны ажилтан
Хаяг : СБД, Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр, Эрүүл мэндийн яамны өргөтгөл, 3 давхар, 304 тоот, 976-11-329369
Цахим шуудангийн хаяг : procurement@hsdp.org

6. Монгол хэл дээр боловсруулсан тендерийн баримт бичгийг авах хүсэлтэй тендер оролцогч нь дээр дурдсан хаягаар хандан энэ тухай албан хүсэлт гаргаж, үл буцаан олгох нөхцөлөөр **350,000.00** (гурван зуун тавин мянга) төгрөгийн төлбөрийг хийнэ. Төлбөрийн нөхцөл нь доорх дансаар дамжуулан шилжүүлсэн байна.

Гадаад шилжүүлэг:		Дотоод шилжүүлэг:	
Payee's Name	: Improving Access to Health Services for Disadvantaged Groups Investment Program	Дансны нэр	: ЭБИЭМТҮХСХОХ МОН3843
Bank Name	: State Bank of Mongolia Ulaanbaatar, Mongolia	Банкны нэр	: Төрийн сан
Payee's Account No.	: 106000076051 (USD)	Дансны дугаар	: 100900011878 (MNT)
SWIFT Code	: STBMMNUB		
Correspondent Bank			
Bank Name	: Kookmin Bank		
SWIFT Code	: CZNBKRSE		
Account No.	: 7968USD019		

7. Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа **2023 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 15 цаг 00 минутаас (Улаанбаатрын цагаар)** өмнө Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр, Эрүүл мэндийн яамны өргөтгөл, 2-р давхар 203 тоот өрөөнд баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусмагц тендерийг нэн даруй нээх ба тендер оролцогчдын төлөөллийг өөрсдийнх нь хүсэлтээр байлцуулна.
8. Захиалагч нь тендер оролцогчийн тендер бэлтгэх, хүргүүлэхтэй холбогдсон аливаа зардлыг хариуцахгүй.